



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 08 өдөр

Дугаар #/433

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зөвлөгөөний үйл ажиллагааны зардалд 5,355,200 (Таван сая гурван зуун тавин таван мянга хоёр зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааны зардлын 5,355,200 (Таван сая гурван зуун тавин таван мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансны "Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хамтын ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагааны дэмжлэг" зардлаас гаргаж, зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН